

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/61/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govिसumber@audit.gov.mn

АЙМГИЙН “БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР”-ЫН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

2022.02.25 № 25.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

008020143

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 <i>Материаллаг байдал</i> .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.3. Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,212,756.00</b>	<b>61,649,995.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>5,988,690.00</b>	<b>5,088,690.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,988,690.00</b>	<b>5,088,690.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>5,988,690.00</b>	<b>5,088,690.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	5,988,690.00	5,088,690.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
34200	Төсөвт байгууллага	1,000,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>51,224,066.00</b>	<b>56,561,305.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>51,224,066.00</b>	<b>56,561,305.00</b>
35410	Бичиг хэргийн материал	33,035,245.00	32,666,760.00
35420	Аж ахуйн материал	10,020,313.00	2,762,670.00
35430	Сэлбэг хэрэгсэл	707,800.00	195,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,082,408.00	304,825.00
35470	Бусад хангамжийн материал	5,378,300.00	20,632,050.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>475,147,108.54</b>	<b>462,166,809.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>475,147,108.54</b>	<b>462,166,809.79</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>151,821,055.54</b>	<b>124,042,767.39</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,000.00	3,500,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-427,777.68	-486,111.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,200,000.00	14,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-620,000.04	-5,353,333.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,527,137.00	27,236,637.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,688,905.39	-13,226,084.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,884,500.00	6,929,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,092,868.59	-2,422,480.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	110,443,805.00	122,083,805.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,604,834.76	-28,419,064.80
39216	Дуусаагүй барилга, байгууламж	15,700,000.00	0.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>323,326,053.00</b>	<b>338,124,042.40</b>
39301	Программ хангамж	4,180,053.00	4,180,053.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-54,000.00	-956,010.60
39303	Бусад биет бус хөрөнгө	319,200,000.00	334,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>533,359,864.54</b>	<b>523,816,804.76</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>533,359,864.54</b>	<b>523,816,804.76</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>533,359,864.54</b>	<b>523,816,804.76</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	361,223,069.00	361,223,069.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>158,196,833.04</b>	<b>121,473,773.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	146,337,570.58	158,196,833.04
51220	Тайлант үеийн үр дүн	11,859,262.46	-9,543,059.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,939,962.50	13,939,962.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>533,359,864.54</b>	<b>523,816,804.76</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>413,821,564.00</b>	<b>305,544,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>68,658,964.00</b>	<b>2,461,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>68,658,964.00</b>	<b>2,461,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,640,270.00</b>	<b>0.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,640,270.00	0.00
120009	Бусад орлого	3,100,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	55,374,261.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,544,433.00	2,461,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>345,162,600.00</b>	<b>303,083,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,500,000.00</b>	<b>500,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,100,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	500,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>341,662,600.00</b>	<b>302,583,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,662,600.00	302,583,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>400,963,625.06</b>	<b>314,407,959.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>400,963,625.06</b>	<b>314,407,959.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>373,796,926.27</b>	<b>288,237,869.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>114,562,922.00</b>	<b>123,113,070.00</b>
210101	Үндсэн цалин	85,103,403.00	81,243,342.00
210102	Нэмэгдэл	25,309,519.00	37,485,728.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,150,000.00	4,384,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,560,712.71</b>	<b>16,479,015.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,183,964.76	11,615,160.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,198,113.00	1,289,924.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	908,091.99	974,821.57
210204	Ажилгүйдлийн даатгал	206,413.46	236,282.65
210205	Эрүүл мэндийн даатгал	2,064,129.50	2,362,825.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,724,525.00</b>	<b>4,621,342.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00
210302	Түлш, халаалт	3,819,146.00	4,169,726.00
210303	Цэвэр, бохир ус	385,379.00	451,616.00
210304	Байрны түрээс	520,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,309,858.65</b>	<b>14,824,753.00</b>
210401	Бичиг хэрэг	1,403,555.00	2,760,485.0
210402	Тээвэр, шатахуун	1,619,600.00	2,177,583.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,692,313.50	1,234,242.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,550.00	0.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	4,868,600.00
210408	Бараа материал акталсны зардал	9,465,840.15	3,723,843.00

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,020,000.00</b>	<b>1,368,800.00</b>
210604	Урсгал засвар	1,020,000.00	1,368,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>651,000.00</b>	<b>722,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	651,000.00	722,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,322,180.00</b>	<b>1,541,470.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,799,920.00	891,220.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,260.00	486,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,800.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	19,200.00	19,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>219,645,727.91</b>	<b>125,567,419.79</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,708,104.36	91,367,121.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,937,623.55	34,040,298.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,166,698.79</b>	<b>26,170,089.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,841,136.00</b>	<b>2,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,841,136.00	2,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>25,325,562.79</b>	<b>23,670,089.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,325,562.79	23,670,089.96
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>12,857,938.94</b>	<b>-36,043,059.79</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>998,676.48</b>	<b>679,999.96</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	230,000.00	679,999.96
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	768,676.48	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>11,859,262.46</b>	<b>-9,543,059.75</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>361,223,069.00</b>	<b>34,962.50</b>	<b>146,337,570.58</b>	<b>507,595,602.08</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	13,905,000.00	0.00	13,905,000.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,859,262.46	11,859,262.46
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>361,223,069.00</b>	<b>13,939,962.50</b>	<b>158,196,833.04</b>	<b>533,359,864.54</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>361,223,069.00</b>	<b>13,939,962.50</b>	<b>158,196,833.04</b>	<b>533,359,864.54</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-9,543,059.75	-9,543,059.75
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>361,223,069.00</b>	<b>13,939,962.50</b>	<b>148,653,773.29</b>	<b>523,816,804.79</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>354,902,870.00</b>	<b>304,083,900.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,740,270.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,740,270.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,640,270.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,640,270.00	0.00
120009	Бусад орлого	3,100,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>345,162,600.00</b>	<b>304,083,900.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,500,000.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,100,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,662,600.00	302,583,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,662,600.00	302,583,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>345,785,180.00</b>	<b>283,243,900.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,785,180.00	283,243,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,618,481.21	257,073,810.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,562,922.00	123,113,070.00
210101	Үндсэн цалин	91,255,301.00	86,533,522.00
210102	Нэмэгдэл	19,157,621.00	32,267,548.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,150,000.00	4,312,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,560,712.71	16,479,015.04
210201	Тэтгэврийн даатгал	10,183,964.76	11,542,512.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,198,113.00	1,223,625.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	908,091.99	990,100.27
210204	Ажилгүйдлийн даатгал	206,413.46	247,525.07
210205	Эрүүл мэндийн даатгал	2,064,129.50	2,475,251.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,724,525.00	4,621,342.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00
210302	Түлш, халаалт	3,819,146.00	4,168,000.00
210303	Цэвэр, бохир ус	385,379.00	453,342.00
210304	Байрны түрээс	520,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,556,249.50	3,088,642.00
210401	Бичиг хэрэг	1,043,500.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,396,400.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,884,349.50	1,234,242.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,000.00	354,400.00
2105	Нормативт зардал	960,000.00	70,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960,000.00	70,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,971,000.00	1,553,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	171,000.00	3,500.00

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210602	Тавилга	0.00	49,500.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>651,000.00</b>	<b>722,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	651,000.00	722,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,322,180.00</b>	<b>1,541,470.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,799,920.00	891,220.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,260.00	486,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,800.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	19,200.00	19,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>169,309,892.00</b>	<b>105,884,871.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,041,692.00	105,584,871.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	268,200.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,166,698.79</b>	<b>26,170,089.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,841,136.00</b>	<b>2,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,841,136.00	2,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>26,325,562.79</b>	<b>23,670,089.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,325,562.79	23,670,089.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>9,117,690.00</b>	<b>20,840,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,129,000.00</b>	<b>21,740,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,129,000.00</b>	<b>21,740,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,129,000.00</b>	<b>21,740,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,129,000.00	21,740,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-3,129,000.00</b>	<b>-21,740,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>5,988,690.00</b>	<b>-900,000.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,988,690.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,988,690.00	5,088,690.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>302,583,900.00</b>	<b>278,913,810.04</b>	<b>23,670,089.96</b>	<b>92.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>302,583,900.00</b>	<b>278,913,810.04</b>	<b>23,670,089.96</b>	<b>92.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>300,083,900.00</b>	<b>276,413,810.04</b>	<b>23,670,089.96</b>	<b>92.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>124,927,000.00</b>	<b>123,113,070.00</b>	<b>1,813,930.00</b>	<b>98.5</b>
210101	Үндсэн цалин	101,065,800.00	86,533,522.00	14,532,278.00	85.6
210102	Нэмэгдэл	19,548,800.00	32,267,548.00	-	165.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,312,400.00	4,312,000.00	400.00	99.9

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,865,200.00</b>	<b>16,479,015.04</b>	<b>386,184.96</b>	<b>97.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,868,100.00	11,542,512.68	325,587.32	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,249,300.00	1,223,625.34	25,674.66	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	999,400.00	990,100.27	9,299.73	99.0
210204	Ажилгүйдлийн даатгал	249,900.00	247,525.07	2,374.93	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,498,500.00	2,475,251.68	23,248.32	99.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,004,000.00</b>	<b>4,621,342.00</b>	<b>382,658.00</b>	<b>92.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	144,000.00	0.00	144,000.00	0.0
210302	Түлш, халаалт	4,168,000.00	4,168,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	692,000.00	453,342.00	238,658.00	65.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,274,400.00</b>	<b>3,088,642.00</b>	<b>185,758.00</b>	<b>94.3</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,000.00	1,234,242.00	185,758.00	86.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	354,400.00	354,400.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>100,000.00</b>	<b>70,400.00</b>	<b>29,600.00</b>	<b>70.4</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	70,400.00	29,600.00	70.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,293,000.00</b>	<b>9,293,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,193,000.00	5,193,000.00	0.00	100.0
210602	Тавилга	2,600,000.00	2,600,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>722,000.00</b>	<b>722,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	722,000.00	722,000.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,165,000.00</b>	<b>1,141,470.00</b>	<b>23,530.00</b>	<b>97.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	491,220.00	8,780.00	98.2
210803	Даатгалын үйлчилгээ	487,000.00	486,050.00	950.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,800.00	90,000.00	2,800.00	96.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	55,000.00	11,000.00	83.3
210807	Газрын төлбөр	19,200.00	19,200.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>138,733,300.00</b>	<b>117,884,871.00</b>	<b>20,848,429.00</b>	<b>84.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,433,300.00	117,584,871.00	20,848,429.00	84.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	302,583,900.00	278,913,810.04	23,670,089.96	92.1
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	302,583,900.00	278,913,810.04	23,670,089.96	92.1
320001	Орон нутгийн төсвөөс	302,583,900.00	278,913,810.04	23,670,089.96	92.1
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	12.00	10.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	6.00		
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,500,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,500,000.00</b>
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>
210602	Тавилга	1,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>400,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>100,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,500,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,500,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	500,000.00
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын данс болон үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, анхан шатанд чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 23 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн байгаль, түүх соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болно” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутагт ойн зурвас, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цөлжилттэй тэмцэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулах, ахуйн болон туурь хог хаягдал бүхий талбайг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлж, менежментийг сайжруулах
- Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг баталсан төсвийн нийт зардал 302,583.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,025.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70.0 хувиар буюу 2,118.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,543.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,988.7	5,088.7	-900.0
Урьдчилгаа	1,000.0	-	-1,000.0
Бараа материал	51,224.1	56,561.3	5,337.2
Үндсэн хөрөнгө	475,147.1	462,166.8	-12,980.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>533,359.9</b>	<b>523,816.8</b>	<b>-9543.1</b>
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	533,359.9	523,816.8	-9,543.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>533,359.9</b>	<b>523,816.8</b>	<b>-9,543.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 900.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн журмын дагуу ахмадуудад хүндэтгэл үзүүлж зарцуулснаас шалтгаалсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,000.0 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилж төлсөн тооцоог хаасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,381.3 мянган төгрөг болж, 12,980.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны бараа материалын үлдэгдлийн зарцуулалттай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 523,816.8 мянган төгрөг болж 9,543.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хасах үр дүнтэй гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 108,276.7 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого 66,198.0 мянга, тусламж, санхүүжилтийн орлого 42,078.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Баталсан нийт төсөвт зардал өмнөх оноос 59,375.6 мянган төгрөгөөр буурсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардал зэрэг зардлуудын бууралтаас шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 313,795.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсөв батлахдаа төсвийн төслийг 11,211.1 мянган төгрөгөөр бууруулж, 302,583.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 302,583.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 278,913.8 мянган төгрөг зарцуулж, 23,670.1 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна.

Баталсан нийт төсөвт зардлын гүйцэтгэл 278,913.8 мянган төгрөг болж, 23,670.1 мянган төгрөг буюу 7.8 хувийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс, НДШ -ийн зардал 2,200.1 мянган төгрөг, байр ашиглалттай тогтмол зардал 382.6 мянган төгрөг, бусад зардал-21,087.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 1,000.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 500.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж, бараа, үйлчилгээний зардалд 1,000.0 мянга, эд хогшил, урсгал завсрын зардалд 500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/19 дүгээр захирамжаар “Агаар, орчныг бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний дагуу 4 зорилт, 19 арга хэмжээний хэрэгжилт 80.0 хувьтай хийгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын “2014-2017 оны хооронд хийгдсэн ойн зурвасын хамгаалалтын хашаануудыг сэргээн засварлах ажил”, “Цоорхойн рашааны хамгаалалтын хашаа, цөөрмийг сэргээн засварлах ажил”, “Сүмбэр сумын Гашууны булгийг хаших ажил”, “Шивээговь сумын Мөнхийн булгийг хаших ажил” зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Хөтөлбөр арга хэмжээний хүрээнд мод үржүүлгийн газрын цахилгааны эх үүсвэрийн ажил, төвийн ногоон байгууламжийн усалгааны ажил, мод үржүүлгийн хүлэмжийн ажил, хууль бус агнуур, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажил, “Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжүүлэх “Хандлагаа өөрчилъе” аяныг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 10 төрлийн 149 мэдээллээс 148 мэдээллийг цаг хугацаанд нь 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн актыг барагдуулаагүй, 2 албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант онд зөрчил давтагдсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 27,180.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 27,180.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, алдаанд 1 зөвлөмж өгсөн болно.

### **4.1 Аудитын явцад залруулга**

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд хийсэн судалгаа, шинжилгээний ажлуудын 27,180.0 мянган төгрөгийг бичиг хэргийн материалын тайлант оны зардлаар хааж, данснаас хассаныг аудитын явцад залруулсан.

### **4.2.2 Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.**

### **4.2.3 Албан шаардлага өгөгдөөгүй**

### **4.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд хийсэн 27,180.0 мянган төгрөгийн судалгаа, шинжилгээний ажлуудын тайланг бичиг хэргийн материалын дансанд буруу бүртгэж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т: "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль

тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” санхүүгийн тайлагналын  
“Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Зөвлөмж:

1. Бичиг хэргийн материалын дансанд бүртгэсэн 4 боть судалгааны ажлын тайланг тусгай  
зориулалтын материалын дансанд шилжүүлэх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06  
дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал  
илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Судалгаа, шинжилгээний ажлын тайланг бичиг хэргийн материалын дансанд бүртгэж, тайланд онд зардлаар хааж данснаас хассан.	1	27,180.0	1	27,180.0								
2	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд хийсэн судалгаа, шинжилгээний ажлуудын тайланг бүртгэхдээ дансны ангилал буруу бүртгэсэн	1	0.0									1	0.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>2</b>	<b>27,180.0</b>	<b>1</b>	<b>27,180.0</b>							<b>1</b>	<b>0.0</b>